



*“Дарь Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 31-ний
өдрийн 24/01 дугаар тогтоолын хавсралт №02*

“ДАРЬ ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Хувилбар № 1

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁР. НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАХ ЭСЭХ ШИЙДВЭР	2
ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ	2
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА	3

"Дарь Финанс ББСБ" ХХК

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү ногдол ашгийн бодлого нь "Дарь Финанс ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргах, энэ талаарх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэ бодлого нь компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Компанийн дүрэм болон холбогдох бусад дүрэм, журмуудад нийцсэн бөгөөд компанийн Ёс зүйн кодексоор тогтоосон шударга ёсны болон тэгш байдлын зарчимд нийцсэн байна.

1.3. "Дарь Финанс ББСБ" ХХК нь Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг бизнесийн үйл ажиллагаандаа зүй зохистой, үр ашигтайгаар захиран зарцуулж, тухайн жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийг боломжтой хэмжээнд байлгахыг эрмэлзэн ажиллана.

ХОЁР. НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАХ ЭСЭХ ШИЙДВЭР

2.1. Компани дараах нөхцөл байдлууд бүрэн хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

2.1.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.1.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.1.3. Компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

2.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах бөгөөд гаргасан шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдэд шийдвэр гарсан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн цахим хуудсаар мэдэгдэнэ.

2.3 Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд тухайн жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тухайн шийдвэрийн үндэслэлийг танилцуулж тайлагнана.

2.4 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт нэгж хувьцаа тус бүрд ногдох ногдол ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргаж бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх, ногдол ашгийг хэрхэн төлөх арга хэлбэр /бэлэн мөнгөөр, үнэт цаасаар эсхүл эд хөрөнгөөр г.м/, ногдол ашгийг төлөх өдөр зэргийг тусгана.

2.5 ТУЗ нь Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг Гүйцэтгэх захирлаас санал болгосныг харгалзан ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг тухайн жилд хэлэлцэж гаргана.

ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ

3.1. Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрөөр тасалбар болгон нэрсийн жагсаалтыг гаргах бөгөөд уг нэрсийн жагсаалтад багтсан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг авах эрх үүснэ.

3.2. Ногдол ашгийг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46 болон 47 дугаар зүйлд заасан нөхцөл, журмыг хангасан байна.

- 3.3. Ногдол ашиг төлөх өдөр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 90-ээс илүүгүй хоног байхаар тооцож, ногдол ашиг тараах хугацааг тогтооно.
- 3.4. Ногдол ашиг төлөх өдрийг он сар өдрөөр нарийвчлан тогтооно. Зөвхөн нэг өдөрт багтаан ногдол ашгийг тараах боломжгүй гэж үзвэл тодорхой өдрүүдийг зааж болно.
- 3.5. Ногдол ашиг тараах үйл ажиллагааг ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ерөнхий нягтлан бодогч гардан гүйцэтгэх бөгөөд Гүйцэтгэх захирал хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.6. Бүртгэлийн өдрөөс хойш ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх хуучин хувьцаа эзэмшигчид үлдэнэ.
- 3.7. Хувьцаа эзэмшигч өөрөө хүсвэл ногдол авахаас татгалзаж болох бөгөөд үүнийхээ төлөө хэнд ч ямар нэг тайлбар гаргах үүрэг хүлээхгүй.
- 3.8. Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр төлбөр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирал болон жилийн эцэст олгоогүй байгаа ногдол ашгийг өглөгийн бүртгэлд бүртгэнэ.
- 3.9. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.
- 3.10. Ногдол ашиг төлсний дараа компанийн ашиг 30-аас дээш хувиар буурсан тохиолдолд ногдол ашиг хуваарилалтын тайланг гаргаснаас хойш ажлын 10 хоногт багтаан Зээлдүүлэгч болон усад зайлшгүй мэдэгдэх үүрэг хүлээсэн этгээдүүдэд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 4.1. Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх удирдлага хариуцна.
- 4.2. Тодорхой ажилтны буруугаас ногдол ашгийг буруу тооцсон, буруу шилжүүлсэн зэрэг алдаа гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанид учирсан хохирлын ерөнхий нягтлан бодогч хариуцна.

--oOo--